



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны
арилжаанд оролцох эрх олгох зохицуулалтын
тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 1/4891 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох шалгалтыг Мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалт болон Мэргэшлийн зөвлөлийн эрх олгох шалгалттай тус тус хамтатгах ажиллагааг зохион байгуулахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т даалгасугай.
2. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 92 тоот тушаалаар батлагдсан "МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ыг хүчингүй болгосугай.
3. Тушаалын 2-т заасан журмыг шинэчлэн батлах хүртэл хугацаанд хавсралтад заасан нөхцөлийг хангасан мэргэжилтэнд "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгож байхаар тогтсугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан 2014 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулахаар зарлагдсан үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох шалгалтанд орохоор бүртгүүлж, төлбөр төлсөн иргэд, байгууллагын төлбөрийг буцаан олгохыг Захиргаа, санхүүгийн газар /Н.Дөл-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
5. Боловсон хүчний мэдлэг, ур чадвараас үүсэн гарах аливаа эрсдэл болон бусад үр дагаврыг хууль, журмын дагуу хариуцан ажиллахыг гишүүн үнэт цаасны компаниудад даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР

Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар
сарын 15-ний өдрийн 209 тоот тушаалын
хавсралт



Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны
арилжаанд оролцох эрх авах мэргэжилтэнд тавих
нөхцөл

1. Мэргэжлийн холбооноос зохион байгуулдаг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтанд хамрагдаж, Санхүүгийн зохицуулах хорооны Мэргэшлийн зөвлөлөөс олгодог үнэт цаасны зах зээлд “Үнэт цаасны зуучлал”-ын үйлчилгээ явуулах эрх авсан ба эрхийн хугацаа хүчинтэй байх,
2. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулсан гишүүн ҮЦК-д үндсэн үйл ажиллагааг хариуцан ажиллаж, зохих хэмжээнд дадлагдажсан байх,
3. Гишүүн ҮЦК-иас тухайн ажилтныг үнэт цаасны арилжаанд оролцуулах тухай албан хүсэлт гаргасан байх,
4. Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, СЗХ болон МХБ-ийн холбогдох журам, “Гишүүний ёс зүйн дүрэм”, МХБ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчиж, сүүлийн 6 сарын дотор хариуцлагын арга хэмжээ авагдаагүй байх.

-----oOo-----